



дөлгөөн хайрхан уул  
**АУДИТ ХХК**

Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн  
хөндлөнгийн хяналтын байгууллага

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо  
Их тойруу-180, Ригэ Хаус байрны 205 тоот  
Утас: (976) 99055711, 99038602  
E-mail: dulguunhairhan\_audit@mongol.net

“ДАРХАНХУНС” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

2015.04.10 № 15/д-89.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хараат бус аудиторын тайлан**

**Санхүүгийн тайлангийн тухай**

Бид “Дарханхунс” ХК-ийн 2014 оны 12 сарын 31-нээрх баланс, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг аудитлалаа.

**Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг байна. Энэхүү үүрэг, хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

**Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний үүрэг, хариуцлага бол хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэхүү стандартаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Аудитын явцад компанид хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, санхүүгийн тайлангуудын бодитой эсэхэд үнэлэлт өгөв.

Бидний олж авсан нотлох зүйл нь энэхүү гаргасан дүгнэлтэд зохистой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

**Дүгнэлт**

Бидний дүгнэлтээр, “Дарханхунс” ХК-ийн 2014 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хүндэтгэсэн, дөлгөөн хайрхан  
Ерөнхий захирал



Б.Пүрэвдулам

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

(мянган төгрөгөөр)			
	Тод	2013 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	22,547.3	12,850.3
Авлага	4	141,283.6	182,065.4
Бусад авлага	5		2,096.3
Бараа материал	7	337,895.4	347,019.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6	7,580.0	5,154.8
Бусад эргэлтийн хөрөнгө			
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)			
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>		<b>509,306.3</b>	<b>549,185.8</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	8	1,108,398.3	1,388,680.7
Биет бус хөрөнгө (цэвэр)			
Биологийн хөрөнгө	9		1,841.7
Бусад эргэлтийн бус хөрөнгө			
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>		<b>1,108,398.3</b>	<b>1,390,522.4</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,617,704.6</b>	<b>1,939,708.2</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>Өр төлбөр</b>			
Богино хугацаат өр төлбөр	10	360,859.3	625,468.0
Урт хугацаат өр төлбөр			
<b>Нийт өр төлбөр</b>		<b>360,859.3</b>	<b>625,468.0</b>
<b>Эздийн өмч</b>			
Дүрмийн сан	11	61,699.9	61,699.9
Халаасны хувьцаа		-	-
Нэмж төлөгдсөн капитал		588,719.7	573,416.1
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		-	-
Эздийн өмчийн бусад хэсэг		606,114.8	606,114.8
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		310.9	73,009.4
<b>Нийт эздийн өмч</b>		<b>1,256,845.3</b>	<b>1,314,240.2</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ДҮН</b>		<b>1,617,704.6</b>	<b>1,939,708.2</b>
			<b>0.0</b>

Нэмэлт тодотгоолууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.





ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

(мянган төгрөгөөр)			
	Тод	2013 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	12	2,396,139.9	2,758,878.9
Борлуулалтын өртөг	13	1,735,255.8	2,022,164.4
<b>Нийт ашиг (алдагдал)</b>		<b>660,884.1</b>	<b>736,714.5</b>
Бусад орлого		8,406.6	1,841.8
Борлуулалт, маркетингийн зардал		-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	14	592,036.2	633,327.2
Бусад зардал	15	29,787.0	21,967.1
Бусад олз (гарз)	16	218.2	21.6
Бусад ашиг (алдагдал)			
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>47,685.7</b>	<b>83,283.6</b>
Орлогын татварын зардал		6,029.3	10,585.1
<b>Татвар дараах ашиг (алдагдал)</b>		<b>41,656.4</b>	<b>72,698.5</b>
<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>			
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>41,656.4</b>	<b>72,698.5</b>
Бусад дэлгэрэнгүй орлого			
<b>Орлогын нийт дүн</b>		<b>41,656.4</b>	<b>72,698.5</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>			<b>0.0</b>

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.



"Дарханхүнс" ХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Гадаад ваютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагд сан ашиг	Нийт дүн
<b>2013 оны 12 сарын 31</b>	61,699.9	588,719.7		606,114.8	(41,345.5)	1,215,188.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>61,699.9</b>	<b>588,719.7</b>		<b>606,114.8</b>	<b>(41,345.5)</b>	<b>1,215,188.9</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					41,656.4	41,656.4
Бусад дэлгэрэнгүй орлого						-
Өмчид гарсан өөрчлөлт						-
Зарласан ногдол ашиг						-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
<b>2013 оны 12 сарын 31</b>	<b>61,699.9</b>	<b>588,719.7</b>		<b>606,114.8</b>	<b>310.9</b>	<b>1,256,845.3</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					72,698.5	72,698.5
Бусад дэлгэрэнгүй орлого						-
Өмчид гарсан өөрчлөлт		(15,303.6)				(15,303.6)
Зарласан ногдол ашиг						-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
<b>2014 оны 12 сарын 31</b>	<b>61,699.9</b>	<b>573,416.1</b>		<b>606,114.8</b>	<b>73,009.4</b>	<b>1,314,240.2</b>





МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

	(мянган төгрөгөөр)	
	2013 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,687,417.9</b>	<b>3,017,244.9</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	2,540,616.4	2,937,379.5
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтын орлого	-	-
Бусад мөнгөн орлого	146,801.5	79,865.4
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>2,542,016.2</b>	<b>2,865,701.4</b>
Ажилчдад төлсөн	451,899.7	570,041.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	127,746.2	135,996.2
Бараа материал худалдан авахад	1,368,230.5	1,592,738.6
Ашиглалтын зардалд төлсөн	116,294.9	115,709.8
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	198,253.7	285,657.6
Хүүний төлбөрт төлсөн	3,304.9	15,534.4
Татварын байгууллагад төлсөн	114,473.7	119,856.4
Даатгалын төлбөрт төлсөн	9,989.3	3,197.5
Бусад мөнгөн зарлага	151,823.3	26,970.0
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>145,401.7</b>	<b>151,543.5</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,000.0</b>	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	2,000.0	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>161,571.6</b>	<b>341,240.5</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	161,571.6	341,240.5
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(159,571.6)</b>	<b>(341,240.5)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>50,000.0</b>	<b>320,000.0</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	50,000.0	320,000.0
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>50,000.0</b>	<b>140,000.0</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	50,000.0	140,000.0
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>180,000.0</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(14,169.9)</b>	<b>(9,697.0)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>36,717.2</b>	<b>22,547.3</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>22,547.3</b>	<b>2,865.3</b>

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.





"Дарханхүнс" ХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2014 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

## ТОДОТГОЛ 1 - Товч танилцуулга

### 1.1. Компанийн тухай:

	"Дарханхүнс" ХК (Аж ахуйн нэгжийн нэр)	Регистр 2050102	Улсын бүртгэлийн дугаар: 1910010001
Захирал:	А.Тунгалаг	Утас: 99946499	е-мэйл:
Ня-бо:	Б.Төрмөнх	Утас:	е-мэйл:

### Өмчийн хэлбэр:

Хувьцаат Компани Дүрмийн сан: 61,699.9 мянган төгрөг

### Компанийн байршил хаяг:

Дархан-Уул, Дархан сум, 5-р баг, Өөрийн байр-01,

### Харилцдаг санхүү, татварын байгууллага:

Дархан-Уул Аймаг санхүү, татварын байгууллагатай харилцдаг.

### 1.2. Үйл ажиллагааны чиглэл:

Талх, талхан бүтээгдэхүүн, Сүү сүүн бүтээгдэхүүн, хүнсний болон өргөн хэрэглээний барааны жижиглэн худалдаа

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

## ТОДОТГОЛ 2 - Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

### 2.1. Санхүүгийн тайлагналын суурь

Компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгийн зарчмаар аккруэл сууриар бэлтгэгдсэн байна.

Компани нь нягтлан бодох бүртгэлээ төгрөгөөр бүртгэдэг ба нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу явагдаж байна.

### 2.2. Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал

Компани нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхдээ санхүү бүртгэлийн "Пирамид-4" програм ашиглан гаргадаг.

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэсэн үндсэн 4 тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудаас бүрдсэн байна.

### 2.3. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд цаашид ч гэсэн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэдэг. Дээрх тасралтгүй үйл ажиллагааны талаарх төсөөлөл нь үр дүн нь тодорхойгүй байгаа ирээдүйд болж болох үйл явцад суурилсан болно.

"Дарханхүнс" ХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2014 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

#### **2.4. Санхүүгийн хэрэгслүүд**

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр нь балансад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, өр төлбөрөөс бүрдэнэ.

#### **2.5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Компанийн хувьд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банкин дахь мөнгө, түүнтэй адилтгах зүйлсээс бүрддэг. Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг.

#### **2.6. Авлага**

Компанийн авлага нь дансны авлага, бусад авлага, татварын авлага, урьдчилж төлсөн зардал, тооцооноос бүрдэнэ.

#### **2.7. Бараа материал**

**Бараа материалын өртөг тодорхойлох.** Худалдан авсан бараа материалын өртөг нь худалдан авсан үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой гарсан бэлтгэл ажиллагааны зардлаас бүрдэнэ.

#### **2.8. Үндсэн хөрөнгө**

**Өртөг:** Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, гаалийн татвар, тухайн хөрөнгийг зориулалтын байршил, нөхцөлд ашиглалтанд оруулахтай холбогдсон бусад зардлуудаас бүрдсэн.

**Элэгдэл:** Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг.

#### **2.9. Орлого**

Тайлант хугацаанд 2,758,878.9 мянган төгрөгийн цэвэр борлуулалт хийсэн ба борлуулалтын орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар хүлээн зөвшөөрсөн.

#### **2.10. Өртөг, зардал**

Борлуулалт, маркетингийн болон ерөнхийн удирдлагын зардлууд, борлуулсан бүтээгдэхүүний өртөг, цалин хөлсний зардал, бусад үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлуудаас

#### **2.11. Татвар**

**ААНОАТ:** Тус компанийн үйл ажиллагаа нь тайлант хугацаанд СТОУС-ын дагуу санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон татварын өмнөх ашгийг Монгол улсын ААНОАТ-ын хууль, түүнд нийцүүлж гаргасан заавар, журмын дагуу татвараас чөлөөлөгдөх орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулан орлогын албан татварыг тодорхойлдог ба санхүүгийн тайлагналыг тасалбар болгох өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээг мөрдөн татварын тооцооллыг хийдэг.

**НД, ХХОАТ:** НД болон ХХОАТ-ыг хуулийн дагуу суутган авч төсөвт төлдөг.

**НӨАТ:** Тус компани нь НӨАТ төлөгч бөгөөд борлуулалтандаа татвар ногдуулж, НӨАТ-тай худалдан авсан бараа, ажил үйлчилгээний татвараар хасалт хийн татварын байгууллагад тайлагнадаг ба хуулийн дагуу ажилладаг.



"Дарханхүнс" ХК  
 Санхүүгийн тайлангийн тодруулгууд  
 2014 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

**ТОДОТГОЛ 3 - Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
<b>Бэлэн мөнгө</b>		
Төгрөг	18,272.4	11,997.7
Доллар	-	-
<b>Бэлэн мөнгөний үлдэгдэл</b>	<b>18,272.4</b>	<b>11,997.7</b>
<b>Банкин дахь харилцах дансны мөнгө</b>		
Төгрөг-ХААН банк 5045450214	931.1	350.4
Төгрөг-ХХ Банк 40301177	537.6	105.0
Төгрөг-ХАС Банк 5000059180	2,529.7	22.1
Төгрөг-Голомт Банк 4315001703		
Төгрөг-Хас банк 5000824598	154.7	246.2
Доллар ХАС банк 5000285165	79.3	93.0
Доллар Голомт банк 4315001704	42.5	36.0
<b>Банкин дахь харилцах дансны үлдэгдэл</b>	<b>4,274.9</b>	<b>852.6</b>
<b>Нийт дүн</b>	<b>22,547.3</b>	<b>12,850.3</b>

**ТОДОТГОЛ 4 - Дансны авлага**

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Бэлтгэн нийлүүлэгч	5,172.2	18,438.0
Ажиллагсадаас авах авлага	54,642.6	46,862.6
Бусад талуудаас авах авлага	20.0	20.0
Худалдан авагчаас	81,339.5	114,469.5
Дараа тайлан авлага		2,166.0
Компани хоорондын авлага	109.3	109.3
<b>Нийт дүн</b>	<b>141,283.6</b>	<b>182,065.4</b>

**ТОДОТГОЛ 5 - Бусад авлага**

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
НӨАТ-ын авлага		2,096.3
Бусад авлага		-
<b>Нийт дүн</b>		<b>2,096.3</b>

**ТОДОТГОЛ 6 - Урьдчилж төлсөн зардал, тооцоо**

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Урьдчилж төлсөн зардал	-	-
Урьдчилж төлсөн тооцоо	7,580.0	5,154.8
<b>Нийт дүн</b>	<b>7,580.0</b>	<b>5,154.8</b>



"Дарханхүнс" ХК  
 Санхүүгийн тайлангийн тодруулгууд  
 2014 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

#### ТОДОТГОЛ 7 - Бараа материал

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Түүхий эд материал	288,224.5	267,417.1
Бэлэн бүтээгдэхүүн	7,583.8	13,333.3
Хангамжийн материал	6,893.4	60,222.9
Сэлбэг хэрэгсэл	8,047.1	5,238.5
Шатах тослох материал	112.2	807.2
Бусад	27,034.4	-
<b>Нийт дүн</b>	<b>337,895.4</b>	<b>347,019.0</b>

#### ТОДОТГОЛ 8- Үндсэн хөрөнгө

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Барилга байгууламж	543,201.5	574,859.1
Хуримтлагдсан элэгдэл	(45,850.1)	(60,097.0)
Машин тоног төхөөрөмж	700,738.5	801,107.9
Хуримтлагдсан элэгдэл	(199,647.5)	(267,940.8)
Тээврийн хэрэгсэл	118,155.2	352,147.4
Хуримтлагдсан элэгдэл	(35,945.9)	(48,992.1)
Тавилга, эд хогшил	22,664.5	34,003.6
Хуримтлагдсан элэгдэл	(8,580.0)	(11,375.5)
Компьютер бусад хэрэгсэл	16,217.8	22,720.4
Хуримтлагдсан элэгдэл	(9,602.2)	(14,231.7)
Бусад үндсэн хөрөнгө	8,043.4	8,288.5
Хуримтлагдсан элэгдэл	(996.9)	(1,809.0)
<b>Нийт дүн</b>	<b>1,108,398.3</b>	<b>1,388,680.7</b>

#### ТОДОТГОЛ 9 - Биологийн хөрөнгө

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Биологийн хөрөнгө		1,907.8
Хуримтлагдсан элэгдэл		(66.1)
<b>Нийт дүн</b>		<b>1,841.7</b>

#### ТОДОТГОЛ 10- Богино хугацаат өр төлбөр

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Дансны өглөг	260,264.8	313,127.8
Цалингийн өглөг	21,565.9	31,236.7
ААНОАТ-ын өглөг	2,475.1	394.5
ХХОАТ-ын өглөг	4,008.1	5,327.1
ЭМ, НДШ-ийн өглөг	3,269.1	13,389.2
ҮЭ-ийн өглөг		701.1

"Дарханхүнс" ХК  
 Санхүүгийн тайлангийн тодруулгууд  
 2014 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

НӨАТ-ын өглөг	8,502.0	
Бусад татварын өглөг	1,342.2	
Богино хугацаат зээл	59,432.1	180,000.0
Ажиллагсаддаг өгөх өглөг		3,758.0
Бусад өглөг		77,533.7
<b>Нийт дүн</b>	<b>360,859.3</b>	<b>625,468.0</b>

#### ТОДОТГОЛ 11 - Эздийн өмч

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Өмч: а) төрийн	-	-
б) хувийн		
в) хувьцаат	61,699.9	61,699.9
<b>Дүн</b>	<b>61,699.9</b>	<b>61,699.9</b>
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	588,719.7	573,416.1
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	606,114.8	606,114.8
<b>Дүн</b>	<b>1,194,834.5</b>	<b>1,179,530.9</b>
Тайлант үеийн ашиг (алдагдал)	41,656.4	72,698.5
Өмнөх үеийн ашиг (алдагдал)	(41,345.5)	310.9
Хуримтлагдсан ашиг алдагдал дүн	310.9	73,009.4
<b>Нийт дүн</b>	<b>1,256,845.3</b>	<b>1,314,240.2</b>

Хөрөнгийн биржийн бүртгэлийн хураамж болон хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбогдож гарсан 15,303.57 мянган төгрөгөөр нэмж төлөгдсөн капитал дансанд өөрчлөлт орсон байна.

#### ТОДОТГОЛ 12 - Үйл ажиллагааны орлого

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Борлуулалтын орлого	2,514,220.7	2,870,002.1
Борлуулалтын хөнгөлөлт (-)	102,942.3	101,961.9
Борлуулалтын буцаалт (-)	15,138.5	9,161.3
<b>Цэвэр борлуулалтын дүн</b>	<b>2,396,139.9</b>	<b>2,758,878.9</b>
Түрээсийн орлого	-	-
Бусад орлого	8,406.6	1,841.8
Бусад орлогын дүн	8,406.6	1,841.8
<b>Нийт дүн</b>	<b>2,404,546.5</b>	<b>2,760,720.7</b>

#### ТОДОТГОЛ 13- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,735,255.8	2,022,164.4
<b>Нийт дүн</b>	<b>1,735,255.8</b>	<b>2,022,164.4</b>



"Дарханхүнс" ХК  
 Санхүүгийн тайлангийн тодруулгууд  
 2014 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

**ТОДОТГОЛ 14 - Борлуулалт, маркетинг, ерөнхий ба удирдлагын зардал**

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Ажиллагсдын цалингийн зардал	357,700.6	348,837.5
НДШ-ийн зардал	42,686.3	52,732.2
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	5,769.3	
Томилолтын зардал	14,972.7	13,435.3
Бичиг хэргийн зардал	2,481.5	
Материалын зардал	18,774.6	33,111.1
Шуудан холбооны зардал	5,880.4	2,342.1
Даатгалын зардал	86.1	
Ашиглалтын зардал	10,702.7	28,498.8
Сургалтын зардал	3,458.1	
Засварын зардал	15,771.2	26,435.7
Элэгдэл, хорогдлын зардал	22,076.2	25,510.2
Түрээсийн зардал	1,230.9	1,070.0
Тээврийн зардал	1,058.1	1,454.9
Шатахууны зардал	18,774.3	20,360.8
Зар сурталчилгааны зардал	30,216.3	20,327.4
Зээлийн хүүгийн зардал		15,534.4
Бусад зардал	40,396.9	43,676.9
<b>Нийт дүн</b>	<b>592,036.2</b>	<b>633,327.2</b>

**ТОДОТГОЛ 15 - Бусад зардал**

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Хандивийн зардал	-	-
Алданги, торгуулийн зардал	17,405.7	225.6
Бусад	12,381.3	21,741.5
<b>Нийт дүн</b>	<b>29,787.0</b>	<b>21,967.1</b>

**ТОДОТГОЛ 16 - Олз (гарз)**

Төрөл	(мянган төгрөгөөр)	
	2013-12-31	2014-12-31
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	59.0	16.5
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	159.2	5.1
<b>Нийт дүн</b>	<b>218.2</b>	<b>21.6</b>

**ТОДОТГОЛ 17 - Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ**

Тайлант хугацаанд холбоотой талуудтай гүйлгээ хийсэн ба энэ нь санхүүгийн тайланд тусгагдсан.

"Дарханхүнс" ХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2014 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

15

**ТОДОТГОЛ 18 - Болзошгүй Өр төлбөр**

Тус компанид 2014 оны 12-р сарын 31-ний байдлаар болзошгүй өр төлбөр байхгүй байна.

**ТОДОТГОЛ 19 - Балансын дараах үйл явц**

"Дарханхүнс" ХК –ийн 2014 оны 12 -р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан гарснаас хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй.

Хүндэтгэсэн:  
Аудитор:

**Э.Нарангэрэл**  
(Мэргэшсэн нягтлан бодогч)





**“ДАРХАНХҮНС” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД**

**ДӨЛГӨӨН ХАЙРХАН УУЛ  
АУДИТ ХХК**

Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн  
хөндлөнгийн хяналтын байгууллага

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо  
Их тойруу-180, Ритз Хаус байрны 205 тоот  
Утас: (976) 99055711, 99038602  
E-mail: dulguunhairhan\_audit@mongol.net

2015.04.10 № 15/2-89

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ**

“Дарханхүнс” ХХК-ийн 2014 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийх явцад бидний анхаарлыг татсан санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийг сайжруулах тухай асуудлуудыг энэхүү тайланд багтаасан болно.

Дотоод хяналтын системийн талаар гүйцэтгэсэн горим нь тус компанийн 2014 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийхтэй холбоотойгоор хяналтын орчны талаар ойлголт авах явдлаар хязгаарлагддаг билээ. Иймд энэхүү горимыг гүйцэтгэх явцад бидний анхааралд өртсөн тодорхой зүйлүүдийг удирдлагад хүргэх зорилгоор энэхүү тайланг толилуулав.

Бидний хийсэн энэ шалгалтын горим нь хяналтын бүх процедур ба аргачлалыг тодорхойлж, дэлгэрэнгүй буюу нарийвчилсан зөвлөмж, заавар өгөх зорилгогүй юм.

Энэхүү тайланг зөвхөн компанийн удирдлагад зориулан бэлтгэснээс бус өөр бусад зорилго агуулаагүй болно.

Тайланд бичигдсэн эдгээр зөвлөмжүүдийн талаар ярилцах эсвэл тэдгээрийг хэрэгжүүлэх ажилд туслалахад бид бэлэн байх болно.

Санхүүгийн тайланд аудит хийх явцад танай компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлд ажиглагдсан зөрчил дутагдал, түүнийг цаашид засч залруулах, сайжруулах талаар бидний өгсөн дараах зөвлөмжүүдийг ажил хэрэг болгоход анхаарч ажиллана гэдэгт итгэж байна.

Энэхүү аудитын ажилд хамтран ажилласан болон аудитын ажлын явцад туслалцаа үзүүлж байсан явдалд компанийн удирдлага, ажилтнуудад талархалаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б. ПҮРЭВДУЛАМ.



## “ДАРХАНХҮНС” ХК

Санхүүгийн тайланд өгөх зөвлөмжүүд  
2014 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

Бид санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийг сайжруулахтай холбогдуулан дараах зөвлөмжүүдийг өгч байна.

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭХТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД

#### Авлага, өглөгийн талаар

##### **Бодит байдал:**

- Дараа тайлангийн баримтууд дутуу, хангалтгүй баримтаар тухайн сарын эцэст хаасан байна
- Бэлтгэн нийлүүлэгчтэй авлага, өглөгийн тооцоо нийлж, акт үйлдэн баталгаажуулаагүй байна.

##### **Зөвлөмж:**

- “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль-ийн дараах заалтыг баримтлан ажиллах,
  - Нягтлан бодох бүртгэл хөтлөлт  
7 дугаар зүйл. Анхан шатны баримт  
7.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.  
7.4. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ.  
7.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.  
7.6. Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.  
7.7. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно. гэснийг мөрдөж ажиллах
  - Сар, улирал, жилээр баланс гаргахын өмнө харилцагчдын авлага, өглөгийн тооцоо нийлж акт үйлдэж байх
  - Авлагын болон өглөгийн насжилтын тайлан тогтмол бэлтгэж удирдах зөвлөлд танилцуулж хэвших.

#### Тээврийн хэрэгсэл худалдан авсан талаар

##### **Бодит байдал:**

- 2014 онд УБ хотоос 9,550.0 мянган төгрөгөөр худалдан авсан Машин/Микро 17-61 ДАХ/ нь баримтаар нотлогдохгүй байна.

##### **Зөвлөмж:**

- Анхан шатны баримтанд үндэслэн ажил гүйлгээг тусгах
- Татварын хяналт шалгалтаар акт тавигдах магадлалтай.

#### Нэмэгдсэн өртгийн албан татварын талаар:

##### **Бодит байдал:**

- Харилцагчдад амталгаанд өгсөн бүтээгдэхүүнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй байна. Тайлант жилд 6,5 сая төгрөгийн өөрийн өртөгтэй бүтээгдэхүүн амталгаанд, 2,67 сая төгрөгийн бүтээгдэхүүн акталсанд НӨАТ ногдуулаагүй байна. / хавсралтаар харуулав/

##### **Зөвлөмж:**

- 13 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.  
13.11. Бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэлийн дотоод эргэлтэд ашигласнаас бусад хэлбэрээр бусдад үнэ төлбөргүй шилжүүлсэн буюу хувийнхаа хэрэгцээнд ашигласан бол нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхгүй. гэснийг мөрдөж ажиллах нь зүйтэй байна.



## “ДАРХАНХҮНС” ХК

Санхүүгийн тайланд өгөх зөвлөмжүүд  
2014 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

Имэн хуулийн 9.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг тэдгээрийн тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэнэ гэснийг мөрдөх./

### Хувь хүний орлогын албан татварын талаар:

#### **Бодит байдал:**

• Тус компани нь хувь хүмүүсээр ажил гүйцэтгүүлсэн, бараа материал худалдан авсан, хувь хүний данс руу мөнгө шилжүүлсэн боловч холбогдох баримтыг шаардлагатай хэмжээнд бүрдүүлээгүй, зохих татвар, суутгалыг хийгээгүй байна.

#### **Зөвлөмж:**

• “ХХОАТ-ын тухай” хууль болон “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай” хуулийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах, иргэний тогтмол бус үйл ажиллагааны орлогоос татвар суутган төлөх, тогтмол үйл ажиллагаа эрхэлдэг бол нотлох баримтыг хангалттай хэмжээнд авч үлдэх шаардлагатай байна.

“ХХОАТ-ын тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасан орлогыг 12 дугаар зүйлийн 12.2-т заасан тогтмол бус үйл ажиллагааны орлогоос ялгахын тулд тухайн татвар төлөгч нь танай байгууллагад байнга бараа, материал, түүхий эд болон тоног төхөөрөмж нийлүүлж байдаг нь тус байгууллагын санхүүгийн баримтаар нотлогдохоос гадна тогтмол үйл ажиллагааны орлого бүхий хувь хүн нь иргэний хуульд заасны дагуу “гэрээ” байгуулж ажилласнаараа тогтмол бус үйл ажиллагааны орлого бүхий татвар төлөгчөөс ялгагдана.

“ХХОАТ-ын тухай” хуулийн 29.1.4.суутгагч нь иргэнд орлого олгох бүрдээ түүний татвар төлөгчийн дугаарыг орлого олгосон тухай баримтад тэмдэглэж, иргэн бүрт олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэх, гэснийг мөрдөж ажиллах,

АУДИТОР

Э.Нарангэрэл  
(мэргэшсэн нягтлан бодогч)